



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр
орон нутагт хийх ажлыг эрчимжүүлэх тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2019 оны удирдах ажилтнуудын зөвлөгөөнөөс гарсан санал, орон нутагт байгаль орчин, аялал жуулчлалын талаар тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, энэхүү албан даалгаврыг хүргүүлэх үндэслэл болж байна.

Иймд яам, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудын ажлын хариуцлага, сахилга дэг журмыг чангатгах, 2019 оны Иргэн төвтэй үйлчилгээний жил болгосонтой уялдуулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг: Ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн талаар:

1.1. Ногоон хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр иргэд олон нийтийн байгаль хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, орчны бохирдол, хог хаягдлыг бууруулахад чиглэсэн “Хандлагаа өөрчилье” багц ажлыг орон нутагт хэрэгжүүлж, эко сургуулиудын үйл ажиллагааг идэвхжүүлж, “Ногоон паспорт” аяныг дэмжих, бизнес эрхлэгчдийн байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэх, эко тэмдэг, ногоон гэрчилгээ олгох байгууллагуудын саналыг ирүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж, бодлого, хөтөлбөрийн биелэлтийг батлагдсан журмын дагуу төлөвлөгөөт хугацаанд нь ирүүлэх.

Хоёр: Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн талаар:

2.1. Монгол Улс албан ёсоор нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенциудын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж биологийн олон янз байдал, экосистем, зэрлэг амьтан ургамал, дэлхийн байгаль, соёлын өвд бүртгэлтэй газруудын хамгааллын менежментийг сайжруулахад орон нутгийн засаг захиргааны зүгээс арга зүйн болон техник туслалцааны дэмжлэг үзүүлэх, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу ногоон эдийн засгийн эргэлтэд оруулахад бүх талаар дэмжиж ажиллах;

2.2. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламжийн газрын асуудлыг яаралтай шийдвэрлэхэд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зүгээс саналаа боловсруулж, Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах ажлыг зохион байгуулах, энэ асуудлыг 2019 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэж тайлангаа ирүүлэх;

2.3. Нэн тэргүүнд устгах шаардлагатай химийн бодисын сав, баглаа боодол, хаягдлыг аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламждаа цуглуулж, эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид шилжүүлэн устгуулах арга хэмжээг яаралтай авах;

2.4. Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хоёрдогч түүхий эдийн цэгүүдэд шилжүүлэхэд шаардлагатай “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ыг яаралтай боловсруулж, 2019 онд аймгийн Засаг даргаар батлуулан мөрдүүлэх;

2.5. Цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд Говьсүмбэрийн нутгийн 62.8%, Дорнодын 43.5%, Дархан-Уулын 31.7%, Сүхбаатарын 31.1%, Дундговийн 27.9%, Дорноговийн 21.9%, Өмнөговийн 17.5% хамрагдаж) байгаа тул эдгээр аймгууд цөлжилттэй тэмцэх, энэ чиглэлээр ажилладаг боловсон хүчнээ чадавхжуулах, цөлжилтийн тархцын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зөвлөмж авч ажиллах;

2.6. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн 27405,46 га газар байгаагаас 1100 газар буюу 8871,18 га талбайд зайлшгүй нөхөн сэргээлт хийх шаардлагатай тул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар холбогдох үүрэг, чиглэлийг аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэх, орон нутгаас байгуулагдаж байгаа комиссын бүрэлдэхүүн нь нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авахдаа хариуцлагатай хандах, Ашигт малтмалын тухай хуулийн 39.7-д заасны дагуу тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын албатай хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх;

2.7. Байгалийн ургамлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хууль бусаар /зөвшөөрөлгүй/ нэн ховор, ховор ургамал түүж бэлтгүүлэхгүй байх тал дээр арга хэмжээ төлөвлөж, ажиллах;

2.8. Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор “Байгалийн ургамлын тухай хууль”-д заасны дагуу 2019 онд үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын төрөлд зүйлийн нэр, хэмжээг судалгаа шинжилгээнд үндэслэн ирүүлэх;

2.9. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Нэн ховор, ховор амьтны үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн тайланг хугацаанд нь журмын дагуу гаргаж ирүүлэх;

2.10. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангаж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах асуудалд онцгойлон анхаарах;

2.11. Эргүүл хяналт, шалгалтыг хийхгүйгээс хулгайн ан гарах, нэн ховор, ховор амьтны эд эрхтэн худалдаалах зөөвөрлөх, хадгалах зэрэг үйлдлүүд их гарч байгаа тул тухайн аймагт орох гарах гарцан дээр хяналт шалгалтыг хийх ажлыг тогтмолжуулах, Агнуурын бүс нутагт Амьтны тухай хууль, Ховор амьтан агнах барих, зөвшөөрөл олгох журам зэргийг мөрдөж ажиллах.

Гурав. Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын талаар:

3.1. Гол мөрний урсцыг нэмэгдүүлэх, усны чанарыг сайжруулах, үер усны аюулаас хамгаалах зэрэг аливаа усны барилга байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

3.2. Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, мөн анхааруулах самбар, тэмдэг байршуулах;

3.3. Сав газрын хэмжээнд ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудыг тоолууржуулах ажлыг зохион байгуулах;

3.4. 2019 онд Дорноговь аймгийн Сайншанд, Хатанбулаг, Говь-Алтай аймгийн Цогт, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, хайгуул судалгааны ажлуудыг хийхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэн гүйцэтгэгч багтай хамтран ажиллах.

Дөрөв.Тусгай хамгаалалттай газар нутгийн талаар:

4.1. Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад болон Сав газрын захиргаадын дарга нар Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар тогтоол, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, 2019 оны 03 дугаар сарын 15-ны дотор холбогдох газруудад хянуулах;

4.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаад хариуцан хамгаалж байгаа газрын биологийн олон янз байдлын суурь судалгаа, байгалийн нөөцийн мэдээллийн санг шинэчлэх, мэдээллийг байршил, орон зайн мэдээллийн сангийн шаардлагад нийцүүлэн үнэн зөв мэдээллийг ирүүлэх;

4.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаад төлөвлөгөөнд хяналт шалгалтыг хийх, холбогдох хууль хүчний байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сургалт сурталчилгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

4.4.Орон нутагт шинээр хэрэгжих болон үргэлжлэн хэрэгжиж буй дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулахтай холбоотой (авто зам, төмөр зам, барилга байгууламж гэх мэт) бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдэд биологийн шүхэр зүйл болсон зэрлэг амьтдын тархац нутаг, амьдрах орчин хамрагдаж байгаа бол тэдгээрийн чөлөөтэй нүүдэллэн шилжих, өсөж үржих хэвийн бололцоог хангасан коридор бүсийг зайлшгүй давхар шийдвэрлэж байх талаар анхаарч зөвлөмж, чиглэл өгч ажиллах.

Тав: Ойн бодлого зохицуулалтын талаар:

5.1.Ой, хээрийн түймрийн эрсдэлийн бүсэд байрлах аймгууд жил бүрийн төсөвтөө түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлын зардлыг тусгах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, түймрээс учирсан хохирлыг тооцож, эзэн холбогдогчийг тогтоон хохирлыг нөхөн төлүүлэх, төлбөр нь эргээд ойг нөхөн сэргээх, ойн бүтээмж, чанарыг дээшлүүлэх арга хэмжээнд хэрхэн зарцуулсан тухай мэдээ, тайланг тухай бүр тогтмол ирүүлж байх,

5.2. Модны эрэлт нийлүүлэлтийг тогтвортой хангах, хууль бус мод бэлтгэлийг бууруулах зорилгоор томоохон суурин газар, аймгийн төвийн модны хэрэгцээг төвлөрсөн зах байгуулж, мэргэжлийн аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлийн бэлтгэсэн модны нийлүүлэлтээр хангадаг менежментийг бүрдүүлж ажиллах,

5.3. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ биологийн болон байгаль орчинд халгүй технологи ашиглах, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд Ойн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс зарцуулах зардлыг хөнөөлийн голомттой талбайн хэмжээгээр төсөвтөө тусгах,

5.4.Ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүгнэлт, Засаг даргын тодорхойлолтыг олгохдоо тухайн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн боловсон

хүчин, багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг хянан магадалж, тавигдах шаардлагыг хангасан нөхцөлд ирүүлж байх.

Зургаа.Төсөв, санхүү, тайлан мэдээ, сургалт сурталчилгааны талаар:

6.1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг тоон үзүүлэлтээр болон бичгээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнг оновчтой тайлагнаж хэвших;

6.2. Байгууллагын балансад бүртгэлтэй эргэлтийн болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад сайтар анхаарч бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах, автомашин, мотоцикл, техник тоног төхөөрөмжид байгууллагын ялгах таних тэмдгийг тавих;

6.3. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан Хамтран ажиллах гэрээ болон Цаг уур, орчны шинжилгээний газар, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”, “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв”, “Ойн судалгааны хөгжлийн төв”, “Аялал жуулчлалын хөгжлийн төв”, “Монгол-Ус”, Байгаль орчин, уур амьсгалын сан, Улсын тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаа, Усны сав газрын захиргаадын дарга нартай байгуулсан 2019 оны Үр дүнгийн гэрээнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнахад анхаарч ажиллах;

6.4. Орон нутагт байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомжийг сурталчлах, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, нутгийн иргэдийн байгаль хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, орчны бохирдол, хог хаягдлыг бууруулахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагаар идэвхтэй явуулж, хамтран ажиллах;

6.5. Байгаль орчны статистик мэдээллийг гаргахад үндсэн мэдээлэл дутуу ирүүлсэн асуудлыг цаашид таслан зогсоох, “БОХ” маягыг үнэн зөв бөглөж ирүүлж байх;

6.6. Төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийг боловсруулж байгаатай холбогдуулан тухайн бүс нутаг, аймаг, сумын хэмжээнд тулгамдсан байгаль орчны тодорхой асуудлыг шийдвэрлэх, 2020-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөрийн саналыг холбогдох журмын дагуу үндэслэлтэй боловсруулж, ирүүлэх.

Долоо.Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын талаар:

7.1. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад стандартын шаардлагыг нэмэгдүүлэх, мөрдүүлэх;

7.2. Үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хүрээнд тус яамнаас аймаг тус бүрд аялал жуулчлалын чиглэлийн 10 мэргэжлээр зохион байгуулах “Аялал жуулчлалын мэргэжил олгох, мэргэшүүлэх” сургалтад орон нутгийн иргэдийг ялангуяа ажилгүй иргэдийг хамруулах;

7.3.Орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

7.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх, эвентүүдийг хөгжүүлэх, өвөл, хавар, намрын улиралд шинэ бүтээгдэхүүн бий болгох, түүнчлэн аймгийн соёлын төвүүдэд жуулчдад зориулсан үзвэрийг тогтсон хуваарийн дагуу бий болгох;

7.5.Жуулчдын аюулгүй байдлыг хангах хүрээнд аялал жуулчлалын гол чиглэл дагуу тэмдэг тэмдэглэгээ, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, энэ чиглэлээр хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих;

7.6.Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд хилийн боомтуудаар жуулчин нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, хил залгаа хот, мужуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан жуулчин аялах нөхцөлийг сайжруулж, тоог нэмэгдүүлэх, хил орчмын аялал жуулчлалын маршрутыг тодорхойлж, Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

7.7.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд гурван үгт хаягжилтад аймгийн бүх үйлчилгээний газрууд, үзмэрүүдийг хамруулах, бие даан жуулчин авах сонирхолтой иргэдэд сургалт явуулж, "AirBnB"-д хамруулахад дэмжлэг үзүүлэх.

8. Энэхүү албан даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр гаргаж, тодорхой хүснэгт, график, зарцуулсан хөрөнгө зэргийг тусган улирал тутам яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж байхыг харьяа байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /В.Жавзан/ нарт тус тус даалгасугай.

САЙД  Н.ЦЭРЭНБАТ